

ВИЗГҮЙ ЗОРЧИХ ЖУРМЫН ТУХАЙ БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ АРДЧИЛСАН ЛАОС АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Бүгд Найрамдах Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Засгийн газар,

тус хоёр улсын хоорондын найрамдалт харицлааг цаашид хөгжүүлэн бэхжүүлэх, иргэдийнхээ зорчих явдлыг хөнгөвчлөх хүсэл эрмэлзлийг удирдлага болгон,

Энэхүү Хэлэлцээрийг байгуулахаар шийдвэрлэж өөрсдийн бүрэн эрхт төлөөлөгчөөр:

БНМАУ-ын Засгийн газар Гадаад явдлын Яамны орлогч сайд нөхөр Жамбалын Банзар,

БНАЛАУ-ын Засгийн газар, Гадаад хэрэг эрхэлсэн төрийн нарийн бичгийн дарга нөхөр Камфай Буфа нарыг томилсонд тэд зохих хэлбэр, журмын дагуу үйлдсэн бүрэн эрхийн үнэмлэхийг харилцан солилцоод дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров.

Нэгдүгээр зүйл

1. Хүчин төгөлдөр дипломат болон албан паспорт бүхий Хэлэлцэн Тохирогч нэгэн Этгээдийн иргэд Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн визгүйгээр түүний нутаг дэвсгэрт нь орж гарах буюу тэнд түр хугацаагаар байх болон нутаг дэвсгэрээр нь дамжин өнгөрч болно.

(2007 оны 9 дүгээр сарын 14-ны өдөр харилцан тохиролцсоны дагуу 1 дүгээр зүйлийн нэг дахь заалтад энгийн паспорттай иргэдийг нэгэн адил хамруулах тухай нэмэлт өөрчлөлт оруулсан.)

2. Энэхүү зүйлийн 1-ийн заалт нь дипломат болон албан паспортаас өөр хүчин төгөлдөр зар бичиг бүхий албан хэргээр яваа хэлэлцэн тохирогч хоёр этгээдийн иргэдэд нэгэн адил хамаарагдана.

Хоёрдугаар зүйл

1. Энэхүү Хэлэлцээрийн нэгдүгээр зүйлд дурдсан зар бичиг бүхий Хэлэлцэн Тохирогч нэгэн Этгээдийн иргэд Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвсгэрт 90 (ер) хоног хүртэлх хугацаагаар байж болно.

Хэлэлцэн Тохирогч аль ч Этгээдийн эрх бүхий байгууллагууд хүндэтгэх шалтгаантай гэж үзсэн тухай бүрдээ Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн иргэний зар бичгийн хүчин төгөлдөр байх хугацаанд нь нутаг дэвсгэртээ байх хугацааг сунгаж болно.

(2007 оны 9 дүгээр сарын 14-ны өдөр харилцан тохиролцсоны дагуу 2 дугаар зүйлийн нэг дахь заалтад 90 (ер) хоног гэснийг 30 (гуч) хоног болгон өөрчилсөн.)

2. Хэлэлцэн Тохирогч хоёр Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газрын гишүүд, захиргаа техникийн болон үйлчлэх албаны хүмүүс тэдгээрийн гэр бүлийн гишүүд эл улсын нутгаар чөлөөтэй орж гарч болно.

Гуравдугаар зүйл

1. Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээд энэхүү Хэлэлцээрийн нэгдүгээр зүйлд дурдсан зар бичгийн загварыг эл хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос 30 (гуч) хоногийн өмнө дипломат шугамаар харилцан солилцоно.

2. Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээдийн аль нэг нь зар бичгээ шинэчилсэн буюу өөрчлөлт оруулсанаа уг зар бичгийг хэрэглэхээс 30 (гуч) хоногийн өмнө Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээддээ дипломат шугамаар мэдэгдэж тэдгээрийн загварыг өгнө.

Дөрөвдүгээр зүйл

Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээдийн иргэд энэхүү Хэлэлцээрийн дагуу зорчихдоо дипломат шугамаар харилцан тохиролцсон хилийн боомтоор нэвтэрч байна.

Тавдугаар зүйл

1. Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн нутагт зар бичгээ үрэгдүүлсэн иргэн энэ тухайгаа уул Этгээдийн орон нутгийн зохих эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэнэ. Тэр эрх бүхий байгууллага нь зар бичгээ үрэгдүүлснийг нь нотолсон магадлагаа олгоно.

2. Дипломат төлөөлөгчийн буюу консулын газар нь энэхүү магадлагааг үндэслэн өөрийн иргэнд тэнд байх, зорчилтоо үргэлжлүүлэх буюу эх орондоо буцаахыг зөвшөөрсөн түр зар бичиг олгоно.

3. Энэхүү зар бичиг нь Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн хилээр уг иргэнийг нэвтрүүлэх эрх олгосон тэр Этгээдийн визтэй байвал зохино.

Зургадугаар зүйл

1. Хэлэлцэн Тохирогч нэгэн Этгээдийн иргэн Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвсгэрт байх хугацаандаа тэр Этгээдийн хууль тогтоомжийг хүндэтгэн сахих ёстой.

2. Энэхүү Хэлэлцээр нь Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн иргэнийг тааламжгүй этгээд гэж нутаг дэвсгэртээ оруулахыг татгалзах, нэгэнт нутаг дэвсгэрт нь байгаа иргэнийг тэнд байх явдлыг зогсоох эрхийг хөндөхгүй.

Долдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийн заалт нь Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвсгэрт байнга оршин суух хүсэлт гаргасан иргэдэд үл хамаарна.

Наймдугаар зүйл

Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээд харилцан тохиролцож нот солилцох замаар энэхүү хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулж болно.

Есдүгээр зүйл

Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээдийн аль нэг нь нийгмийн аюулгүй байдлыг хангах буюу эрүүлийг хамгаалах зорилгоор энэхүү хэлэлцээрийн үйлчилгээг түр зогсоож болно. Ийнхүү үйлчилгээг түр зогсоосноо Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээддээ дипломат шугамаар даруй мэдэгдэх ёстой.

Аравдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийг тодорхой хугацаагүйгээр байгуулсан бөгөөд Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээдийн аль нэг нь түүнийг цуцлах тухайгаа бичгээр мэдэгдсэн өдрөөс хойш гурван сар болоод хүчингүй болно.

Арван нэгдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээр гарын үсэг зурснаас хойш 45 (дөчин тав) хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

Энэхүү Хэлэлцээрийг 1978 оны зургадугаар сарын 8-ны өдөр Улаанбаатар хотноо монгол, лао, франц хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд монгол, лао хэл дээрх эх нь адил хүчинтэй байна. Хэлэлцээрийн монгол, лао хэл дээрх эхийн заалтыг тайлбарлахад зөрөө гарвал франц хэл дээрх эхийг баримтална.

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ӨМНӨӨС**

Гарын үсэг

**БҮГД НАЙРАМДАХ АРДЧИЛСАН
ЛАОС АРД УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ӨМНӨӨС**

Гарын үсэг

**ВИЗГҮЙ ЗОРЧИХ ЖУРМЫН ТУХАЙ БНМАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗАР,
БНАЛАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНД 1978 ОНЫ ЗУРГАДУГААР САРЫН 8-
НЫ ӨДӨР УЛААНБААТАР ХОТНОО БАЙГУУЛСАН
ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХАВСРАЛТ**

Энэхүү Хэлэлцээрийн нэгдүгээр зүйлийн дагуу дор дурдсан зар бичиг бүхий БНМАУ-ын иргэдэд улсын хилийг нэвтрэх эрхийг олгоно. Үүнд:

1. Дипломат паспорт
2. Албан паспорт
3. Гадаад паспорт
4. Гадаад паспортын хавсралт
5. БНМАУ-д буцах үнэмлэх

Энэхүү Хэлэлцээрийн нэгдүгээр зүйлийн дагуу дор дурдсан зар бичиг бүхий БНАЛАУ-ын иргэдэд улсын хилийг нэвтрэх эрхийг олгоно. Үүнд:

1. Дипломат паспорт
2. Албан паспорт
3. Гадаад явдлын яамны тусгай үнэмлэхтэй энгийн паспорт
4. Хамтын паспорт